



ХҮҮХЭД ӨСВӨР ҮЕИЙГ ИВЭЭХ ТӨВИЙН ТӨВЧ ТАНИЛЦУУЛГА

Байгууллагын тухай

Хүүхэд Өсвөр Үеийг Ивээх Төв нь 2005 оноос хүүхдийн хөгжил, оролцоо, хамгаалал болон эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Бид хүүхэд, өсвөр үеийнхний сайн сайхан амьдралын төлөө өөрсдийн оюуны нөөц бололцоо, итгэл зүтгэл, хүч хөдөлмөрөө зориулан ажилладаг.

Эрхэм зорилго:

Хүүхэд, өсвөр үеийнхний бүх талын хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаанд манлайлан оролцох, хүүхэд өсвөр үеийнхний оролцоо, эрүүл мэндийг дэмжсэн төв байгуулан ажиллах

Зорилт:

- Хүүхэд, өсвөр үеийнхний бүх талын хөгжлийг дэмжих
- Хүүхэд, эцэг эх, олон нийтийн санал санаачлагыг дэмжих
- Хүүхдийн оролцоог дэмжих
- Хүүхэд, өсвөр үеийнхнийг осол гэмтэл, эрсдэлт зан үйлээс урьдчилан сэргийлэх болон эрүүл мэндийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулах

Үнэт зүйлс:

- Мэргэшсэн ажилтнууд
- Шинэ санал санаачлага, бүтээлч байдал
- Нийгмийн хариуцлага
- Бидний дэмжлэг шаардлагатай байгаа хүүхэд, өсвөр үеийнхэн

Хамрах хүрээ:

- Хүүхэд, өсвөр үеийнхэн
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, өсвөр үеийнхэн
- Эцэг эх, асран хамгаалагч
- Хүүхэдтэй ажиллаж буй багш, мэргэжилтнүүд

Үйл ажиллагааны чиглэл

- Хүүхдийн оролцоо: Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллага болох “БИД” клубыг чиглүүлэн ажиллах, дэмжлэг үзүүлэх
- Эрүүл мэнд: Эрүүл мэндийг дэмжих, эрсдэлт зан үйлээс урьдчилан сэргийлэх, бэлгийн боловсрол олгох
- Хүүхэд, өсвөр үеийнхнийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх
- Чадваржуулах: - Эцэг эх, багш, мэргэжилтнүүдийн чадавхийг нэмэгдүүлэх
- Хүүхэд, өсвөр үеийнхэнд зөвлөгөө мэдээлэл өгөх
- Сургалт сурталчилгааны үйл ажиллагаа зохион байгуулах

Хаяг:

Сүхбаатар дүүрэг, 1-р хороо Фламинго оффис 6 давхарт, 605 тоот

Утасны дугаар: 99031337 /Б.Мөнхцэцэг/